Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хоол үйлдвэрлэл үйлчилгээний хүнсний хангамж, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Лхагвасүрэн Бадамцэцэг

# 2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. 1.1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж, хангамжийн тогтолцоог сайжруулж, мэргэжлийн хүний нөөцтэй байна. | | | | | | | |
| 1 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг үдийн сүүгээр хангах “Өдөр бүр нэг аяга сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэх /ҮАХ- | -Хөтөлбөрт хамрагдсан сурагчдын тоо -Гүйцэтгэлийн хувь | 78400 | 80000 | “Сүү хөтөлбөр"-ийн хүрээнд Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Орхон, Төв, Хэнтий, Дархан-Уул зэрэг 12 аймаг болон нийслэл, нийт 97 цэцэрлэг, 144 ерөнхий боловсролын сургуулийн нийт 85,262 суралцагч эцэг эх, орон нутгийн дэмжлэгтэйгээр тус хөтөлбөрт хамрагдаад байна. Хөтөлбөрийн хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 3.1 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна. Боловсролын ерөнхий газрын 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 1/662 дугаар албан бичгийн дагуу сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар авах арга хэмжээний чиглэл”-ийг аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. Тус зөвлөмжийн хоёрдугаар хэсэгт сүү, сүүн бүтээгдэхүүнийг 7 хоногт 2-оос доошгүй удаа хоолны цэсэд төлөвлөх чиглэл өгсөн. Боловсролыг ерөнхий | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.2.2.13/ | | | | газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/73, 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/135 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар 14, 158, 52, 31, 124, 28, 145, 55, 116, 29, 63, 302, 1, 160, 38,10, 186 дугаар цэцэрлэг, нийт 17 цэцэрлэг, ЕБ-ын сургуулийн хоолны цэсэд хяналт хийхэд 7 хоногт 2-3 удаа сүү, сүүн бүтээгдэхүүнийг оролцуулсан хоолны цэс төлөвлөн хэррэгжүүлж байна.<br>Хавсралт: 2 файл | сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 2 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүнсний хангамжийн тогтолцоог сайжруулах, хагас боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн ерөнхий гэрээний аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах | - Ерөнхий гэрээ зарлуулсан бүтээгдэхүүний багцын тоо - Гүйцэтгэлийн хувь | 23 | 72 | Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлд нийлүүлэх гол нэрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг ерөнхий гэрээний аргаар худалдан авах талаар ЗГ-ын 162 дугаар тогтоолд тусгагдсаны дагуу нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэх 74 нэр төрлийн түүхий эд бүтээгдэхүүний үнэ, техникийн шаардлагыг боловсруулсан. Төрийн худалдан авах ажиллагааны газарт 3 удаа БЕГ-ын даргын 1/33, 1/942, 1/950, тоот албан бичгээр хүргүүлж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд тендерийн өмнөх уулзалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газрын хурлын танхимд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, уулзалтад хүнсний түүхий эд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдааны чиглэлийн аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл нийт 30 гаруй албан хаагч оролцсон. https://user.tender.gov.mn/.../invit.../detail/1731910656424<br>Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн тайлангаас үзэхэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар цахим дэлгүүрт байршсан 14 аж ахуй нэгж байгууллагаас 20 цэцэрлэг, 59 ерөнхий боловсролын сургууль, 2 их сургууль нийт 81 байгууллага 45 нэр төрлийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг 545,507,358 төгрөгөөр худалдан авалт хийж 71,660,795 төгрөгийн хэмнэлт гаргасан. https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1739333394436<br>Хавсралт: 8 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 3 | Боловсролын | -Зохион байгуулсан | 11 | 4 | Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлийн хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр | 1-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлийн хүний нөөцийн ур чадварыг сайжруулах, мэргэшүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна. | сургалтын тоо - Гүйцэтгэлийн хувь | | | сургалт, үйл ажиллагааг үе шаттай төрийн болон олон улсын байгууллага хамтран нийт 5 удаагийн сургалт зохион байгуулж 403 албан хаагчдыг хамруулсан. Үүнд. 1. “Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Боловсрол ба эрүүл мэнд” сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд нийт 87 албан хаагч, 2. Дархан-Уул аймгийн хүүхдийн хоолны чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор "Хүүхдийн хоол шим тэжээл, сургалт арга зүйн үндэсний төв", ШУТИС-тэй хамтран 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр аймгийн хоол зүйч, тогооч нийт 120 албан хаагч; 3. Төв аймгийн цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүнсний хангамжийн тогтолцоог сайжруулах сургалт 2025 оны 03 дугаар сарын 28-ний өдөр нийт 103 албан хаагч; 4. Хүүхдийн хоолны мэргэшүүлэхийн хоол зүйчдэд Хүнсний хангамж, ерөнхий гэрээний талаарх сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр 13 хоол зүйч; 5. "Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээл сургалт арга зүйн үндэсний төв"-тэй хамтран эхний хагас жилийн байдлаар нийт 4 сургалтыг зохион байгуулж 80 албан хаагчийн хамруулсан. Хоол зүйчийн мэргэшүүлэх, тогоочийн мэргэшүүлэх"MASTER TRANER" , хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан төрийн албан хаагчдад зориулсан сургалтуудыг зохион байгуулсан.<br>Хавсралт: 22 файл | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 1.2. 1.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүнсний хангамж, хоол, шим тэжээлийн талаарх мэдлэг боловсрол, хүний нөөцийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, стандарт дүрэм журмын хэрэгжилтэд шинжилгээ судалгаа хийх, үнэлэх сайжруулах арга хэмжээний санал боловсруулах, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, тайлагнах | | | | | | | |
| 4 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол | - Хэлэлцүүлгийн тоо - Боловсруулсан | - | 1 /хэлэлцүүлэг/ | Ерөнхий боловсролын сургуулийн жишиг гал тогоо, хоол үйлдвэрлэх орчны тооцоолол гаргах, хүний нөөцийн нөхцөл байдалд хийх үнэлгээний шалгуур боловсруулах ажлын хүрээнд МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилагаар хэрэгжүүлж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрийн хүрээнд | 1-р сар, 2-р сар, 3-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэл, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах, жишиг гал тогоо, хоол үйлдвэрлэх орчны тооцоолол гаргах, хүний нөөцийн нөхцөл байдалд хийх үнэлгээний шалгуур боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулах | шалгуурын тоо | | | НЭМҮТ-тэй хамтран ажиллаж 1 зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлсэн. Үүнд: Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний орчин нөхцөлийн сайжруулах, жишиг гал тогооны орчны тооцоолол гаргах ажлыг судлаачтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Тус зөвлөх үйлчилгээгээр суудлын тоо, барилгын хүчин чадлаас хамаараад 114,778,000-301,010,500 төсөв шаардлагатай тооцоолол гарсан. Зөвлөх үйлчилгээний үр дүнг хэлэлцүүлэх үйл ажиллагааг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, дүүргүүдийн хоол хүнсний асуудал хариуцсан мэргэжилтнүүд, төрийн ба төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хоол зүйч нийт 83 албан хаагчдад зохион байгуулж НЭМҮТ-д БЕГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 1/1111 тоот албан бичгээр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүлээлгэн өгсөн.<br>Хавсралт: 10 файл | сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 5 | Сургууль, цэцэрлэгийн хоол хүнсний чанар | -Хамрагдах байгууллагын тоо -Гүйцэтгэлийн хувь | 96 | 20/100/ | Сургууль, цэцэрлэгийн хоол хүнсний чанар хүртээмж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр зөвлөн туслах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд мэргэжилийн байгууллагуудыг оролцуулан 2 удаагийн ажлын хэсгийг байгуулан нийт 45 байгууллагад хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Үүнд: 1. Боловсролыг ерөнхий газрын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр зөвлөн туслах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна. | | | | даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/73 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүнсний чанар хүртээмж, аюулгүй байдлыг хангах, төрийн худалдан авах ажиллганы газрын цахим дэлгүүрт байршсан аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинэилгээ, үнэлгээ, зөвлөн туслах чиглэлээр 14, 158, 52, 31, 124, 28, 145, 27 дугаар сургууль 302, 1, 160, 38 дугаар цэцэрлэг, 16 аж ахуй нэгж байгууллага нийт 28 байгууллагаар 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 04 сарын 25-ны өдрийн хооронд яналт-шинэилгээ, үнэлгээ, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Тус хүрээнд 14, 158, 52, 31, 124, 28, 145, сургуулиудын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчны үнэлгээг Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт, үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийж ажилласан. Ерөнхий боловсролын 7-н сургууль, 4-н цэцэрлэг нийт 11 боловсролын байгууллагад үнэлгээ хийхэд 14, 31, 124, 145 дугаар сургуулиуд 65%-аас 79%-ийн хооронд үнэлэгдэж III дугаар түвшин, 158, 52, 28 дугаар сургуулиуд, 71, 38, 302, 160-дугаар цэцэрлэгүүд 65%-иас доош оноо авч IV дүгээр түвшинд тус тус үнэлэгдсэн. 2.Боловсролыг ерөнхий газрын даргын 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/135 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар ХҮҮ-г бусдаар гүйцэтгүүлдэг сургуулийн түрээсийн гэрээг дуусгавар болгох чиглэлээр 133, 102, 33, 44, 97, 84, 12, 104, 105, 162, 55, 116, 29, 63, хөгжил, БЗЦ буюу 68-р сургууль,10, 186 дугаар цэцэрлэгт 2025 оны 05 дугаар сарын 28 -ны өдрөөс 2025 оны 06 дүгээр сарын 06 -ны өдрийн хооронд хяналт-шинэилгээ, үнэлгээ, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан.<br>Хавсралт: 9 файл | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 6 | Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, | -Хамтарсан байгууллагын тоо -Гүйцэтгэлийн хувь | 3 /төсөл хөтөлбөр/ | 1/орон нутаг/, 100 | Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын байгууллагатай хамтран 2025 оны эхний хагас жилийн байдлаар 4 ажил арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Үүнд: 1.НҮБ-ын Хүүхдийн сангийн хүүхдийн таргалалтаас сэргийлэх чиглэлээр хүүхэд, залуучууд, гэр бүлд чиглэсэн эрүүл, шим тэжээллэг хооллолтыг дэмжих “FIX MY FOOD” компанит ажлыг хамтран хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд дунд ахлах ангийн сурагчдын хоол шим тэжээлийн байдлыг сайжруулах | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын байгууллагатай хамтран ажиллах | | | | зорилгоор БЕГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/65 тоот тушаалаар ЕТГ, БЯ, ЭМЯ, ХХААХҮЯ, ХГБХХЕГ, ШУТИС, НҮБ, ДЭМБ, ДЗОУБ, МХЭАХНХолбоо байгууллагуудын төлөөллийг оролцуулан нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн хурлаар 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж 2025 онд зохион байгуулах ажлын төлөвлөөг хэлэлцэж БЕГ-ын даргаар батлуулсан. 2. Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ны өдөр хүртэлх хугацаанд Увс, Дорнод аймгийн 4 сургуулийн хоол тэжээлийн орчны судалгааг зохион байгуулсан. 3. Увс аймгийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор цэцэрлэг, сургуулийн гал тогоог жишиг байдлаар тохижуулах, сургуулийн хоол зүйчийн жишиг өрөө, танхимыг шинээр байгуулах ажлыг хэрэгжүүлэхээр ДЗМОУБ-тай уулзалт зохион байгуулж, БЕГ-ын даргын 1/2094 тоот албан бичгээр сургууль, цэцэрлэгийн бодит нөхцөл байдал , шаардлагатай тооцоо судалгааг хүргүүлсэн. 4. Койка олон улсын байгууллагын төслийн хүрээнд байгуулагдсан "Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт арга зүйн үндэсний төв"-ийн 2025 онд зохион байгуулагдах хоол зүйч тогоочийн мэргэшүүлэх үндсэн бол давтан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг БЕГ-ын даргын А/141/, А/144 тоот тушаалуудаар тус тус батлуулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Хавсралт: 15 файл | сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 7 | Орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгэ | - Хамрагдсан орон нутгийн тоо<br>- Гүйцэтгэлийн хувь | 1 /Дархан -Уул/ | 1/100 | Орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний хүнсний хангамжийн тогтолцоог сайжруулах хүрээнд 3 аймгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэх нийт 164 Дархан /76/, Орхон /53/, Увс /35/ нэр төрлийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүний үнэ, техникийн шаардлагыг боловсруулсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах хүсэлтийг БЕГ-ын даргын 1/1561, 1/2085 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Дархан -Уул аймгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эний хүнсний хангамжийн тогтолцоог сайжруулах зорилгоор ерөнхий гэрээ зарлах | | | | ерөнхий гэрээний аргаар худалдан авах ажиллагааг 2 удаа зохион байгуулж 2 ААН шалгарсан. https://www.facebook.com/share/p/1DvRBY4tLV/ Хавсралт: 5 файл | 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 8 | Дэлхийн хоол зүйч нарын өдрийг тохиолдуулан арга хэмжээ, өдөрлөг зохион байгуулах | -Зохион байгуулсан арга хэмжээний тоо -Гүйцэтгэлийн хувь | - | 1/100/ | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Сургуулийн хоол зүйчийн эрх, үүргийн сурталчлан таниулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Дэлхийн хоол зүйч нарын өдрийг тохиолдуулан Монгол улсад хоол зүйч мэргэжлийн үүсэл хөгжил ба түүхэн замнал, мэргэжлийн үнэ цэнэ, ажлын байрны эрэлт хэрэгцээ, үүний дотор сургууль цэцэрлэгт хоол зүйчээр ажиллахын давуу тал, хоол зүйчийн ажил, байдлын талаарх мэдээ, мэдээллийг “Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт арга зүйн үндэсний төв” -тэй хамтран 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Тус өдөрлөгт ШУТИС, Хүрээ МХТДС, АШУҮИС, Технологийн дээд сургуульд Хоол зүйч, хоол зүй шим судлал мэргэжлээр суралцаж буй 60 гаруй оюутан, багш нар оролцсон бөгөөд оюутнууд хоорондоо танилцаж, харилцан туршлага судалж хэлэлцсэн. 2. Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Эрүүл монгол хүн үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Хоол зүйч мэргэжлийн талаар видео бэлтгэн Боловсролын ерөнхий газрын пэйж хуудсаар дамжуулан түгээн дэлгэрүүлсэн. Хандалт 9,8к үзэлттэй байна. https://www.facebook.com/watch/?mibextid=D5vuiz&v=717534520785068&rdid=zr6UAOufBVF8XIXB 3. Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах арга зам хэлэлцүүлгийг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зүүн Финляндын их сургуультай хамтран 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж, удирдамж батлуулсан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 9 | Өнгөний системд суурилсан цэс төлөвлөлтийг ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлнэ | Арга хэмжээнд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн тоо | - | 200 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд өнгөний системд суурилсан нэгдсэн цэс нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: 1. "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар авах арга хэмжээний чиглэл"-ийг аймаг нийслэлнийн боловсролыг газарт 2025.02.13-ны 1/662 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус зөвлөмжийн 2.1 дэх хэсэгт "Орон нутгийн онцлог улирлын шинж чанар, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын нас биеийн онцлогт тохирсон шим тэжээлийн тэнцвэртэй хоолны жишиг нэгдсэн цэс боловсруулж нэгж байгууллагыг мэргэжил арга зүй, нэгдсэн удирдлагаар хангах" чиглэлийг хүргүүлсэн. 2.Аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүдэд "Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоолны цэсэд өнгөний систем нэвтрүүлэх арга зүй" сэдэвт сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 17, 05 дугаар сарын 01-ны өдрүүдэд 2 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан. ШУТИС-тай хамтран зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 65 албан хаагч хамрагдсан. 3. Өнгөний системд суурилсан шим тэжээлийн тэнцвэртэй хоолны цэс төлөвлөх арга зүйн видео контентыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран бэлтгэж нэгж байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангаж ажилласан. (https://www.facebook.com/share/v/1AuX9QQBAB/?mibextid=wwXIfr) /2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 21,1 мянган үзэлттэй байна/ 4.Үйл ажиллагааны үр дүнд Баянхонгор /32/, Булган /22/, Дундговь /18/, Өвөрхангай /34/, Сүхбаатар /16/, Завхан/ 31/, Орхон /17, /Увс /27/ чингэлтэй дүүрэг /19/ 8 аймаг 1 дүүрэг нийт 216 сургууль нэгдсэн жишиг цэс нэвтрүүлж хоол үйлдвэрлэл, үйлчилгээг зохион байгуулж байна. Нэгдсэн цэс хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд ХҮҮ-г нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, хүнсний | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүтээгдэхүүний хэрэгцээг тооцох, хоолны чанарт хяналт тавих боломж бүрдсэн. Хавсралт: 9 файл | | |
| 10 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүнсний хангамжид орон нутгийн хүнсний нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ | -Судалгаанд хамрагдсан орон нутгийн тоо -Хүргүүлсэн зөвлөмжийн тоо | - | 22 /орон нутаг/ | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заасан нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэх хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг худалдан авалтын талаарх судалгааг БЕГ-ын даргын 1/1976, 1977 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар төрийн өмчийн нийт 705 сургууль, 1024 цэцэрлэг хүүхдийн хоолны хүнсний түүхий эд бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу амжилттай зохион байгуулсан сургууль 364 буюу 51.6%, цэцэрлэг 394 буюу 38.4 % байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй болон оролцогч орж ирээгүйгээс шалтгаалан шууд худалдан авалт хийж буй сургууль 341 буюу 48,4%, цэцэрлэг 630 буюу 61,6 % байна. Бусад худалдан авалт хийж буй эх үүсвэрийг үзэхэд зах худалдааны төвөөс сургууль 108 буюу 15.3%, цэцэрлэг 80 буюу 7,8%, хүнсний дэлгүүрээс сургууль 142 буюу 20.1% , цэцэрлэг 125 буюу 12.2 %, хувь хүнээс сургууль 41 буюу 5,8%, цэцэрлэг 122 буюу 12% худалдан авалт хийсэн. 2. Нийслэлийн хүүхдийн хоол үйлдвэрлэл,үйлчилгээнд хүнсний түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлж буй 4 ОНӨААТҮГ-ын нөхцөл байдлын судалгаа авахаар БЕГ-ын даргын 1/1424, 1/1730 тоот албан бичгийг Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй, Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. Тус байгууллагуудаас нийслэлийн 305 цэцэрлэг хүүхдийн хоолны хүнсний түүхий эд бүтээгдэхүүн худалдан авч байна. Хавсралт: 7 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 11 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөг | Гүйцэтгэлийн хувь | - | Гүйцэтгэлийн төлөвлөгөө | 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг системд оруулж эхний хагас жилийн байдлаар ирсэн 30 бичгийг шийдвэрлэж, 44 албан бичиг нэгж байгууллагуудад хүргүүлж, А/тушаал 4-ыг гаргаж ажилласан. | 1-р сар, 2-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | боловсруулж, батлуулан, хагас жилийн тайлан бичиж үнэлүүлсэн байна. | | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 1 | Архив, | -Хүлээлгэн | 2024 | Хэлтсий | Койка төслийн хүрээнд байгуулагдаж буй "Хүүхдийн хоол | 1-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулах | өгсөн баримтын тоо - Гүйцэтгэлийн хувь | онд зохион байгуулсан 2 ажлын материал болон гүйцэтлэгийн төлөвлөгөө, тайлан архивт хүлээлгэн өгсөн. | н архивын материалыг жагсаалтын дагуу архивлан хүлээлгэн өгсөн байна. | үйлдвэрлэл, шим тэжээл, сургалт арга зүйн үндэсний төв", Засгийн газрын 162 дугаар тогтоолын хүрээнд Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэх хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн материал, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс, мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг архивлан хүлээлгэн өгсөн. | сар, 2-р сар, 3-р сар | |
| 13 | Удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу нэгдсэн мэдээ, мэдээлэл, тайланг | Тайлан танилцуулга /тоо/ | 68 мэдээ мэдээлэл бэлтгэн оруулсан. | Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан мэдээг тухайн бүрт | Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөх сургалт зохион байгуулах чиглэлээр төрийн болон олон улсын байгууллагатай хамтран 2025 оны эхний хагас жилийн байдлаар 5 удаагийн сургалт зохион байгуулж 403 албан хаагчдыг хамруулж 2 тайлан бичиж, Боловсролын ерөнхий газрын сайтад нийт 13 хэвлэлийн мэдээ бэлтгэн түгээн дэлгэрүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Боловсролын яамтай хамтран | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэн танилцуулах | | | танилцуулах | зохион байгуулсан "Хүүхдийн хоол" хэлэлцүүлэгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны 2024-2025 оны статистик мэдээллийг 21 аймаг, 9 дүүргээс авч нэгтгэн Боловсролын яамтай хамтран гарын авлага гаргасан. - Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллаж буй тогоочийн "Орон тооны норматив" одоогоор батлагдаагүй байгаа энэ ажлын хүрээнд 21 аймаг 9 дүүргээс судалгаа авч нэгтгэн 1 тогоочид ногдох нормативын мэдээг Боловсролын яаманд хүргүүлсэн.<br>Хавсралт: 9 файл | сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Зохистой хооллолт ба эрүүл мэнд сургалтад хамрагдсан байна. | -- | 2024 онд нийт 4 удаагийн гэрчилгээтэй сургалтад хамрагдсан. | Сургалтад хамрагдсан байна. | 1."Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 16,17-ны "Зохистой хооллолт ба боловсрол" сургалтад | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдаж гэрчилгээ авсан. 2. Койка олон улсын байгууллагын Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах төслийн хүрээнд Солонгос улсын хоол зүйчдийн холбооны гишүүний Төрийн албан хаагчдад зориулсан сургалтад хамрагдсан. Хавсралт: 2 файл | сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 2 | Байгууллага дотоодоос зохион байгуулсан сургалтад хамрагдах | Зохион байгуулсан сургалтад тухай бүрт хамрагдаж, ажлын чиглэлийн дагуу хэрэгжүүлэн ажиллана. | нийт 3 удаагийн сургалтад хамрагдсан. | Г.Зохион байгуулж буй сургалтад тухай бүрд хамрагдаж, нэгж байгууллагуудад мэдээ, мэдээлэл хүргэх | 2025 оны 05 дугаар сарын 08 -ны өдөр БЕГ-ын 202 тоотод Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн танилцуулга сургалтад хамрагдсан | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 1% |
| 3 | Хуулийн чиглэлээр их дээд сургуульд хамрагдах | Хуулийн хэрэглээг зөв уншиж, ажлын чиг үүрэгт ашиглаж хэвших | - | 1-р курст хичээлүүдээ судалж шалгалт өгсөн байна. | Их засаг их сургуульд Эрх зүйч мэргэжлээр суралцаж 1-р курсээ амжилттай төгссөн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хоол үйлдвэрлэл үйлчилгээний хүнсний хангамж, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Лхагвасүрэн Бадамцэцэг
/................................................./ Огноо: ........................